



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
БАЯНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2022 оны 06 сарын 30 өдөр

Дугаар А/67

Баянбулаг

Ардын Хувьсгалын 100 жилийн ойн  
хурдан морины уралдаан зохион  
байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 02 дугаар зүйлийн 2.4, 13 дугаар зүйлийн 13.1.1, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 07 дугаар зүйлийн 7.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ардын Хувьсгалын 100 жилийн ойн баяр наадмын хурдан морины уралдааныг 2022 оны 07 дугаар сарын 01-02-ны өдрүүдэд зохион байгуулан уяачдын гаргасан амжилтыг нөхөн тооцсугай.

2. Хурдан морины уралдааныг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Д.Энхтөр (Хөдөө аж ахуйн тасгийн дарга)

Гишүүдэд: Г.Өлзий-Орших (Баянбулаг 05 дугаар багийн Засаг дарга)

Б.Батбаатар (Цэцэрлэгийн нярав)

Г.Түмэнболд (Нягтлан бодогч)

М.Даваахүү (Их эмч)

Г.Энхбаяр (Эмнэлгийн нийгмийн ажилтан)

Т.Нямжанцан (Байгаль хамгаалагч)

М.Цэвээнсүрэн (Хөтөлбөрийн ажилтан)

Д.Эрдэнэсүвд (БЭЭЭЭГ мал эмнэлгийн эрхлэгч)

Д.Энэбиш (Эмнэлгийн жолооч)

Ж.Уламбадрах (Дэлгэрэх 02 дугаар багийн Засаг дарга)

Б.Даваадарь (Хөтөлбөрийн ажилтан)

Д.Энхамгалан (Худгийн ажилтан)

Б.Дашням (Сумын МСУХ тэргүүн)

3. Хурдан морины уралдааны үеийн хүүхдийн аюулгүй байдал, бусад зохион байгуулалттай холбоотой төхөөрөмж, дамжуулалт зэргийн бэлтгэл ажлыг сайтар хангаж, хамгаалах хэрэгсэл, даатгал, зөвшөөрөгдсөн нас, эцэг эхийн зөвшөөрөл зэрэг шаардлагууд дээр хяналт сайн тавьж ажиллахыг морины комиссын даргад үүрэг болгосугай.

4. Уралдаан зохион байгуулахтай холбогдон гарах шагнал урамшуулалын зардлыг ивээн тэтгэгчид болон бусад эх үүсвэрээс санхүүжүүлэхийг нягтлан бодогч, Багийн Засаг дарга нар, сумын морин спорт, уяачдын холбоонд даалгасугай.

ДАРГА  ГАНСҮХ



642201059

2022 on zahiramj